## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2022/65/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2022 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг<br>Утас: 70432545<br>цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл........ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........ 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........ 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........ 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 9
3. Аудитын тайлан........ 9
3.1 Ерөнхий зүйл........ 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт........ 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........ 11
3.4 Материаллаг байдал........ 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........ 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........ 13
3.8 Аудитын гол асуудал........ 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал........ 13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........ 13
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 14
4. Аудитын илрүүлэлт........ 14
4.1 Залруулсан алдаа........ 14
4.2 Албан шаардлага........
4.3 Зөвлөмж........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ҮЕНЧ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ТАНАА

2022.02.22. № 2/54
танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **28,787,635** | **73,697,425** |
| **33** | **АВЛАГА** | 320,300 | 29,521,253 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 300,000 | 1,469,253 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 28,052,000 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 28,467,335 | 44,176,172 |
| **351** | **Түүхий эд материал** | 13,215,214 | 16,787,826 |
| 35130 | Эм боох материал | 13,215,214 | 16,787,826 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,252,121 | 27,388,346 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 26,541 | 85,800 |
| 35420 | Аж ахуйн материал | 50,400 | 48,900 |
| 35460 | Хүнсний материал | 441,750 | 129,353 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 14,733,429 | 27,124,293 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **439,912,029** | **456,286,335** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 439,912,029 | 456,286,335 |
| **392** | **Биет хөрөнгө** | 427,912,029 | 444,286,335 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 391,756,035 | 391,756,035 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (55,818,856) | (66,504,414) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 76,679,444 | 96,679,444 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (37,738,472) | (49,568,333) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 149,895,658 | 187,288,571 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (120,489,433) | (141,239,985) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,607,397 | 47,793,297 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,959,745) | (34,898,279) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 12,980,000 | 12,980,000 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 12,000,000 | 12,000,000 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,000,000 | 12,000,000 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **468,699,663** | **529,983,760** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,433,321** | **1,864,367** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,433,321 | 1,864,367 |
| **413** | **Өглөг** | 4,433,321 | 1,864,367 |
| **4136** | **Бусад өглөг** | 4,433,321 | 1,864,367 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,554,306 | 788,921 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 879,015 | 1,075,446 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **464,266,343** | **528,119,394** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 464,266,343 | 528,119,394 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 247,668,384 | 247,668,384 |
| 51101 | Өмч: - төрийн | 247,668,384 | 247,668,384 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (54,394,333) | 9,458,718 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (54,394,333) | (54,394,333) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 63,853,051 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 270,992,292 | 270,992,292 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **468,699,663** | **529,983,760** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **491,572,820** | **705,853,109** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,269,800** | **94,030,690** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 27,269,800 | 94,030,690 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 27,269,800 | 94,030,690 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 27,269,800 | 94,030,690 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **60,777,220** | **611,822,419** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 427,433,100 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 403,525,800 | 427,433,100 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,315,700 | 150,756,603 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 100,279,803 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,315,700 | 50,476,800 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 22,012,200 | 22,424,800 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 22,012,200 | 28,052,000 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 34,449,320 | 33,632,716 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 34,449,320 | 32,969,730 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | - | 662,986 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **521,898,922** | **642,000,058** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **521,898,922** | **642,000,058** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 521,578,222 | 611,400,058 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 317,387,933 | 367,186,004 |
| 210101 | Үндсэн цалин | 313,730,220 | 352,033,600 |
| 210102 | Нэмэгдэл | 3,657,713 | 15,152,404 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,390,753 | 45,280,958 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,390,753 | 45,280,958 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,676,507 | 19,897,016 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,589,389 | 2,532,016 |
| 210302 | Түлш, халаалт | 16,758,318 | 17,365,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,716,271 | 45,311,240 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,995,300 | 2,704,241 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,755,671 | 34,102,915 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,372,500 | 1,406,000 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,592,800 | 7,068,084 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 30,000 |
| **2105** | **Нормативт зардал** | 47,438,185 | 80,147,924 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,762,144 | 67,983,276 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 8,212,549 | 10,239,948 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,463,492 | 1,924,700 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,849,500 | 1,492,000 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,894,000 | 1,492,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 753,926 | 1,284,960 |
| 210702 | Дотоод албан томилолт | 753,926 | 1,284,960 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,755,281 | 595,450 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000 | 200,000 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 173,600 | 290,450 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 80,000 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 18,550 | 25,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58,609,867 | 50,204,506 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,897,814 | 5,000,000 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 45,712,053 | 45,204,506 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 320,700 | 30,600,000 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000 | 30,600,000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000 | 30,600,000 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(30,326,102)** | **63,853,051** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(30,326,102)** | **63,853,051** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 247,668,384.00 | 270,992,291.67 | -24,088,530.86 | 494,572,144.81 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **247,668,384.00** | **270,992,291.67** | **-24,088,530.86** | 494,572,144.81 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -30,326,101.98 | -30,326,101.98 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **247,668,384.00** | **270,992,291.67** | **-54,394,332.84** | 464,266,342.83 |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **247,668,384.00** | **270,992,291.67** | **-54,394,332.84** | 464,266,342.83 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **247,668,384.00** | **270,992,291.67** | **-54,394,332.84** | 464,266,342.83 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 63,853,050.84 | 63,853,050.84 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **247,668,384.00** | **270,992,291.67** | **9,458,718.00** | 528,119,393.67 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **464,303,020** | **583,790,719** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **464,303,020** | **583,790,719** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 403,525,800 | 427,433,100 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,315,700 | 100,300,103 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,315,700 | 100,300,103 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 22,012,200 | 22,424,800 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 22,012,200 | 22,424,800 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 34,449,320 | 33,632,716 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 662,986 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 34,449,320 | 32,969,730 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **464,303,020** | **583,790,719** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **464,303,020** | **583,790,719** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **463,982,320** | **552,571,233** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 292,616,076 | 357,069,720 |
| 210101 | Үндсэн цалин | 182,863,774 | 205,425,357 |
| 210102 | Нэмэгдэл | 83,459,874 | 126,863,608 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,028,127 | 4,961,000 |
| 210104 | Урамшуулал | 19,264,300 | 19,819,755 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,160,724 | 49,418,883 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,327,124 | 35,656,983 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,958,400 | 3,440,500 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,366,700 | 2,752,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 591,700 | 688,100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,916,800 | 6,880,900 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,093,854 | 21,196,700 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,576,389 | 3,775,300 |
| 210302 | Түлш, халаалт | 17,097,665 | 16,975,000 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 419,800 | 446,400 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,358,315 | 35,925,000 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,516,500 | 1,200,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,810,671 | 30,225,000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,531,144 | 2,000,000 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,500,000 | 2,500,000 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,757,860 | 40,943,235 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,448,890 | 30,943,235 |
| 210502 | Хоол, хүнс | 8,999,845 | 8,000,000 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,309,125 | 2,000,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,955,500 | 2,228,100 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,000,000 | 1,000,000 |
| 210604 | Урсгал засвар | 955,500 | 1,228,100 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 753,926 | 1,708,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 753,926 | 1,708,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 24,805,655 | 1,437,500 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000 | 200,000 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000 | 300,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 80,000 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 18,550 | 25,000 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 832,150 | 832,500 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,480,410 | 42,600,595 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,480,410 | 42,600,595 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **320,700** | **31,262,986** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000 | 31,262,986 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 662,986 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000 | 30,600,000 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 492,989,900 | 482,871,130 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 492,989,900 | 482,871,130 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 492,989,900 | 482,871,130 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 344,046,900 | 333,928,130 |
| 210101 | Үндсэн цалин | 207,861,500 | 205,425,357 |
| 210102 | Нэмэгдэл | 105,194,000 | 103,722,018 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,048,000 | 4,961,000 |
| 210104 | Урамшуулал | 24,943,400 | 19,819,755 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,446,300 | 46,446,300 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,684,400 | 32,684,400 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,440,500 | 3,440,500 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,752,400 | 2,752,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,100 | 688,100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,880,900 | 6,880,900 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,196,700 | 21,196,700 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,775,300 | 3,775,300 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 16,975,000 | 16,975,000 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 446,400 | 446,400 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,925,000 | 35,925,000 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000 | 1,200,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,225,000 | 30,225,000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,000,000 | 2,000,000 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,500,000 | 2,500,000 |
| **2105** | **Нормативт зардал** | 36,009,400 | 36,009,400 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 26,009,400 | 26,009,400 |
| 210502 | Хоол, хүнс | 8,000,000 | 8,000,000 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,000,000 | 2,000,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,228,100 | 2,228,100 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,000,000 | 1,000,000 |
| 210604 | Урсгал засвар | 1,228,100 | 1,228,100 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 700,000 | 700,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 700,000 | 700,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,437,500 | 1,437,500 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000 | 200,000 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000 | 300,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000 | 80,000 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25,000 | 25,000 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 832,500 | 832,500 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,000,000 | 5,000,000 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000 | 5,000,000 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 492,989,900 | 482,871,130 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 427,433,100 | 427,433,100 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 427,433,100 | 427,433,100 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 22,424,800 | 22,424,800 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 22,424,800 | 22,424,800 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 43,132,000 | 33,013,230 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 43,132,000 | 33,013,230 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 29.00 | 29.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 19.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 620004 | Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,135,000** | **100,963,089** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,135,000** | **100,963,089** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,135,000 | 69,700,104 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 23,141,590 |
| 210101 | Үндсэн цалин | | 23,141,590 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 2,972,583 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 2,972,583 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 3,790,916 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 3,790,916 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,135,000 | 36,945,015 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,135,000 | 36,945,015 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 1,842,000 |
| 210604 | Урсгал засвар | | 1,842,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 1,008,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,008,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 31,262,985 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 31,262,985 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | 662,985 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 30,600,000 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,135,000 | 100,963,089 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,135,000 | 100,963,089 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,135,000 | 100,300,104 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 662,985 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж

заасны дагуу Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд орлого төвлөрүүлэлт, төсвийн зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг 2022 оны 02 дугаар сарын 18-нөөс 2021 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Эрүүл мэндийн төв нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

***<u>Эрхэм зорилго</u>***: *Үенч сумын Эрүүл мэндийн төв нь "Баруун бүсийн загвар эрүүл мэндийн төв болох" алсын хараагаа тодорхойлон ард иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэж, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх замаар, ард иргэдийнхээ дундаж наслалтыг уртасгана" гэсэн эрхэм зорилго тавин ажилласан байна.*

***Үйл ажиллагааны чиглэл***:*Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулан, хүн амын эрүүлжүүлэх үйлсэд уламжлалт анагаах ухааныг өргөн ашиглах, ард иргэдэд эрүүл мэндийнхээ төлөө зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх явдал тухайн байгууллагын үйл ажиллагааны гол чиг үүрэг болон ажиллажээ.*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ *Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04-р сарын 30-ны 67/А268 тоот тушаалаар "ковид-2019 эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг батлах тухай"*
- ✓ *Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07-р сарын 26-ны А/496 тушаалаар "ковид-2019 эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг урамшуулах мөнгөн тэтгэмж олгох" тухай*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад 2021 онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 642.1 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 6.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61.2 сая төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд төрийн сангийн харилцах дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны үлдэгдэл 44.2 сая төгрөг болж 15.7 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 3.5 сая төгрөг, бусад хангамжийн материал 12.2 сая төгрөгөөр шинэчилсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 116.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 34.2 сая төгрөгөөр нийт 150.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 134.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Авлагын данс оны эхэнд 320.3 мянган төгрөг байснаас оны эцэст 29.5 сая төгрөг болж өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны цэвэр үлдэгдэл оны эхэнд 439.9 сая төгрөг байсан бол оны эцэст 456.3 сая төгрөг болж 16.4 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 686.9 сая төгрөг байсан бол оны эцэст 748.5 сая төгрөг болж 61.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.7 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 59.8 сая төгрөгийн хөрөнгө орлого авсантай холбоотой байна. Тайлант оны эцэст 456.3 сая төгрөгийн цэвэр хөрөнгийн үлэгдэлтэй байна

Тайлант оны эцэст 1.8 сая төгрөгийн өр үүссэн байгаа нь ХАОАТ дутуу төлсөн 1.0 сая төгрөг, эмийн өр 788.9 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 247.7 сая төгрөг байсан оны эцэст 247.7 сая төгрөг болж тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт хийгдээгүй тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 9.5 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн санхүүжилтээр 427.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 22.4 сая төгрөгөөр, ЭМД-аас 43.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 492.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ЭМГ-аас тус байгууллагын төсвийг төсвөөс 427.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 22.4 сая төгрөг, ЭМД-аас 43.1 сая төгрөг нийт 492.9 сая төгрөг батлан ирүүлжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 492.9 сая төгрөгийн төсөв баталснаас 427.4 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 22.4 сая төгрөг, ЭМД-аас 43.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ЭМГ-аас төсвийн санхүүжилтийг 427.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 22.4 сая төгрөг, ЭМД-аас 33.0 сая төгрөгөөр нийт 482.8 сая төгрөгөөр санхүүжүүлж ЭМД-аас санхүүжих санхүүжилтийг эрүүл мэндийн үйлчилгээний гүйцэтгэлээр 10.1 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 482.9 сая төгрөг буюу 100 хувь зарцуулж төсвийн хэмнэлт гаргаагүй тайлант оны үйл ажиллагааны зардлыг батлагдсан төсвийн хэмжээнд бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар аймгийн ЭМГ-аас ковид-2019 цар тахлын үеэр ажилласан илүү цаг, томилолт, вакцины урамшуулал болох 69.7 сая төгрөг, ЭМЯ-наас сайдын тушаалаар эрүүл мэндийн ажилчдын нэг удаагийн буцалтгүй тусламж 30.6 сая төгрөг нийт 100.3 сая төгрөгийн санхүүжилт авч өр, авлагагүй бүрэн зарцуулсан харилцах дансанд үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсноор Ковидын үеийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн эмийн багцын тооцоо байхгүй, ХАЭМ-ийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгааны төлөвлөгөөний биелэлт гаргаагүй зориулалт бус зарцуулсан, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн гүйцэтгэлээр өр тусгагдаагүй үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн байхад санхүүжилтийн авлага тусгаж орлого үр дүнд хий орлого нэмэгдүүлсэн байгааг дараагийн аудитаар авч үзэх.

## 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон: Шатахууны тооцоо хийгээгүй, тайлан хангалтгүй гаргасан, жолоочийн замын хуудас засвартай гарын үсгээр баталгаажуулаагүй, алсын дуудлагын бүртгэл байхгүй, олгосон талон нь хаашаа явж байгаа бүртгэл хийсэн анхан шатны баримтгүй,

Аюулгүй нөөцийн хугацаа хэтэрсэн эмийн устгалт хийгдээгүй, хоорондын тооцоо нийлж акт үйлдээгүй эмийн орлого харилцахын зарлагаас тулгахад эмийн үнэ илүү шилжүүлсэн, захиалгын эмийн тайланд засвар их хийсэн, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа асуудал нөлөөлсөн.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 156 мэдээллээс 111 хугацаандаа мэдээлэл оруулсан, 26 мэдээлэл хугацаа хоцроосон 19 мэдээлэл мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл авсан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал ковидоор зарцуулсан санхүүжилтийн зарцуулалтыг авч үзэх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 127.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн төлбөрийн 1 акт, 28.0 сая төгрөгийн 3 зөвлөмж, бараа материал, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 98.1 сая төгрөгийн залруулга хийсэн.

### 4.1 Залруулсан алдаа

***1.1 Шилэн данстай холбоотой***

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

*Илрүүлэлт: Шилэн дансны 156 мэдээлэл оруулахаас 26 мэдээлэл хугацаа хоцроон оруулсан, 5 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлого, зарлагын 19 гүйлгээ оруулаагүй, 111 мэдээл оруулсан*

*Шийдвэрлэлт:* *Санхүүжилтийн орлогын 12 мэдээлэл, 5.0 сая төгрөгөөс дээш гүйлгээ хийсэн зарлагын 7 мэдээлэл аудитын хугацаанд шилэн дансны сайтад нөхөн оруулсан.*

***1.1 Бараа материалын данстай холбоотой***

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

*Илрүүлэлт: Эм нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдтэй хоорондын тооцоо нийлж баримт үйлдээгүй, захиалгын эмийн тайланд засвар их хийсэн, няравын тайлан гаргалт хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэл иж бүрэн биш 66.4 сая төгрөг, Аж ахуйн нэгж байгууллагуудаас бараа материал худалдан авахдаа и-баримтгүй гүйлгээ хийсэн, суутгаагүй албан татварын тайлан илгээгүй 21.5 сая төгрөг, Шатахууны тооцоо бодож хэвшээгүй, тайлан хангалтгүй гаргасан, жолоочийн замын хуудас засвартай гарын үсгээр баталгаажуулаагүй, алсын дуудлагын бүртгэл, хоорондын тооцоо эмчийн тооцооны хуудсаар баталгаажаагүй, хувь машинд олгосон шатахууны тооцоо хийгээгүй, замын хуудсаар баталгаажаагүй 10.1 сая төгрөг,*

*Шийдвэрлэлт:* *Дээрх алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн аудитын явцад алдааг засуулж залруууллаа.*

**4.2 Төлбөрийн акт**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1.2 Орлоготой холбоотой асуудал***

*Илрүүлэлт: Цалингийн урамшуулал олгоод хүн амын орлогын албан татвар дутуу суутган авч төсвийн орлого бүрэн бүрдүүлээгүй, цалингийн тооцоололлууд үнэн бодитоор илэрхийлэгдээгүй,*

*Шийдвэрлэлт: Хүн амын орлогын албан татварын дутуу суутгалыг төсвийн орлогод төвлөрүүлэх 498.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоох*

***1.3 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт: Аж ахуйн нэгжтэй тооцоо хийсэн актууд баримтаар нотлогдохгүй, бараа материалын орлого, харилцахын зарлага зөрүүтэй 1,2 сая төгрөгийн эмний үнэ илүү шилжүүлсэн байна.*

*Шийдвэрлэлт: Эм ханган нийлүүлэгч болох Ховд-эм хангамж кампани 569.3 мянган төгрөг, Мөнхийн тун ХХК-ны 588.7 мянган төгрөг, Мөнх цэлмэг ирээдүй ХХК-ны 25.0 мянган төгрөгийн илүү төлсөн мөнгөний тооцоо хийж байгууллагад оруулах төлбөрийн акт тогтоох*

**4.4 Зөвлөмж**

***1.7 Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт: Ковидын үеийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн эмийн багцын тооцоо, тайлан байхгүй, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн гүйцэтгэлээр дутуу өгсөн үйл ажиллагааны зардлын өр тусгагдаагүй, үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн байхад санхүүжилтийн авлага тусгаж орлого үр дүнд хий орлого нэмэгдүүлэн бодит бус авлага үүсгэж буруу тайлагнасан 28.9 сая төгрөг,*

*Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, өглөг авлагын тооцоог бодитоор хийх, дотоод хяналтыг сайжруулах, дараа онд зарцуулах санхүүжилтийн үр өгөөжийг бий болгох*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Аймгийн ЗДТГ | 7 | 127.8 | 3 | 98.1 | 1 | 1.7 | | | 3 | 28.0 |

**ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**